

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2018 оны . . . дугаар сарын . . . ны
өдрийн . . . дугаар тушаалын хавсралт

МАЛ, АМЬТНЫ ХАЛДВАРТ ӨВЧНИЙГ ТАНДАХ, ҮР ДҮНГ МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мал, амьтны халдарт өвчний дэгдэлтийн тархалтын хүрээг тогтоох, халдварт өвчнийг илрүүлэх, эрүүлийг баталгаажуулах, вакцины дараах дархлааны идэвхийг шалгах зорилгоор тандалт явуулах, үр дүнд дүн шинжилгээ хийж бүх шатны мал эмнэлэг болон холбогдох байгууллага, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах, мэдээллийн бааз бүрдүүлэх, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Төрийн болон хувийн өмчийн бүх шатны мал эмнэлгийн байгууллага нь мал, амьтны халдварт өвчний тандалт зохион байгуулах, үр дүнгийн тухай мэдээ, тайланг гаргахдаа халдварт өвчнийг тандах, үр дүнг мэдээлэх журмыг / цаашид “ журам” гэх/ баримтална.

Хоёр. Хамрах хүрээ, тандалтын тогтолцоо, нэгжийн үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Халдварт өвчний тандалт явуулах нэгж нь төрийн болон хувийн өмчийн бүх шатны мал эмнэлгийн байгууллага байна.

2.2. Тандалт нь хэд хэдэн салбарыг хамарсан эсхүл дотоод, гадаадын төсөл хөтөлбөр, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон тохиолдолд гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ.

2.3. Тандалтанд дэгдэлтийн үеийн халдварын тархалтыг тогтоох, халдварт өвчнийг илрүүлэх, эрүүлийг баталгаажуулах болон вакцины дараах дархлааны идэвхийг шалгах үйл ажиллагаа багтана.

2.4. Вирус, бактери, мөөгөнцөр болон паразитаар үүсдэг нэг организмээс нөгөө организмын хооронд тархдаг өвчнийг тандах ба тандалтыг идэвхитэй ба идэвхигүй гэсэн 2 хэлбэрээр гүйцэтгэнэ.

2.5. Идэвхигүй тандалтыг оношлогоо, шинжилгээний үр дүн, мэдээллийн бааз дээр суурилж гүйцэтгэх ба мэдээг эпидемиологийн долоо хоногоор /цаашид даваа гаригаас ням гариг дуусталх хугацааг эпидемиологийн долоо хоног гэж үзэх/ нэгтгэн даваа гариг бүр цахимаар мэдээлнэ.

2.6. Тархвар зүйчийн удирдлаган доор шинжлэгч эмч болон бусад мэргэжилтэнг оролцуулсан баг бүрдүүлэх, тандалтын удирдамж боловсруулах, дээж авах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах ажлыг идэвхитэй тандалтаар гүйцэтгэнэ.

2.7. Идэвхитэй тандалт хийх ажлын хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно.

2.8. Тандалт хийх ажлын удирдамжийг зохион байгуулж байгаа шат шатны байгууллагын дарга батална.

2.9. Тандалтын сорьц авах, шинжилгээ хийх үед холбогдох журам, зааврыг мөрдөнө.

2.10. Идэвхитэй тандалтын үр дүнг нэгтгэсэн тайланг тодорхой заасан хугацаанд багтаан холбогдох дээд байгууллагад цахим болон албан бичгээр хүргүүлнэ. Тайланг удирдамж, тоо баримт, асуумж судалгаа, тоон өгөгдлийн дүн шинжилгээ, үр дүн, зөвлөмж болон бусад мэдээллийг тодорхой тусгасан байхаас гадна шаардлагатай бол зураг, дүрс

бичлэг хавсаргаж болох бөгөөд холбогдох удирдлага гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

2.11. Тандалтын тоон баримт, мэдээллийн урсгалыг цэгцтэй, хялбар болгох, хянах, хадгалалт, ашиглалтыг сайжруулах, тэдгээрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “лабораторийн цахим бүртгэлийн систем”-ийг ашиглана.

2.12. УМЭАЦТЛ нь “Лабораторийн цахим бүртгэлийн системийг тандалтанд ашиглах заавар”-ыг боловсруулж, уг системийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

2.13. Эпидемиологийн нэгж нь тандалтын мэдээ, тайланг нэгтгэж боловсруулан дүн шинжилгээ хийх, график зураглалаар гаргах, эргэж мэдээлэх, мэдээллийн санд оруулах ба хариу арга хэмжээний төлөвлөлтөнд ашиглана.

2.14. Мал, амьтны халдварт өвчний тандалтын үйл ажиллагааг улсын хэмжээнд төлөвлөх, хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах, тандалтын тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, шийдвэр гаргагчид мэдээлэх ажлыг эпидемиологийн нэгж гүйцэтгэнэ.

2.15. Эпидемиологийн нэгжийн боловсруулсан тандалтын мэдээ, саналд суурилан шийдвэр гаргана.

Гурав. Тархвар зүйчийн гүйцэтгэх үүрэг

3.1. Тус журмын 2.5; 2.6; 2.10; 2.11; 2.13 –д заасан үүргийг гүйцэтгэнэ.

3.2. Харьяа мал эмнэлгийн нэгжээс тандалтын долоо хоногийн мэдээг цаг хугацаанд, бүрэн гүйцэт ирүүлсэн байдалд хяналт тавина.

3.3. Сорьц цуглуулах, хадгалах, холбогдох лабораторид хүргүүлсэн эсэхэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд зохицуулалт хийнэ.

3.4. Халдварт өвчний дэгдэлт бүртгэгдсэн үед судалгааны багийг удирдах ба “Дэгдэлтийн үеийн тандан судалгаа”-г хийж үр дүнг нэгтгэх ба бусад мэдээллэд дүн шинжилгээ хийж шийдвэр гаргагчийг үнэн зөв мэдээллээр хангана.

3.5. Зонхилон тохиолддог халдварт өвчнийг өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд тооцож хариу арга хэмжээг төлөвлөхөд мэдээллээр хангана.

3.6. Тандалтын тоон мэдээллээр мэдээллийн сан үүсгэн аюулгүй байдлыг ханган ажиллана.

Дөрөв. Шинжлэгч эмчийн гүйцэтгэх үүрэг

4.1. Тус журмын 2.6; 2.9; 2.11 –д заасан үүргийг гүйцэтгэнэ.

4.2. Тандалтын сорьцыг хүлээн авч шинжилгээг гүйцэтгэж хариуг тархвар судлалын асуудал хариуцсан мэргэжилтэнд мэдээлнэ.

4.3. Лабораторийн багаж тоног төхөөрөмж, урвалж, оношлуур, шил сав, биоаюулгүйн тоног төхөөрөмж, сорьц хадгалах, зөөвөрлөхөд шаардлагатай хэрэгсэл, нөөцийн бэлэн байдлыг хангана.

4.4. Сорьц авалт, тээвэрлэлт, хадгалалт, шинжилгээний баталгаажуулалтын байдалд дүгнэлт хийж эргэн мэдээлнэ.

Тав. Мал эмнэлгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эпидемиологийн нэгжийн гүйцэтгэх үүрэг

5.1. Тус журмын 2.6; 2.13; 2.14-д заасан үүргийг гүйцэтгэнэ.

5.2. Эпидемиологийн нэгжээс тандалтын мэдээ, тайлан, зөвлөмж цаг хугацаандаа, бүрэн гүйцэт ирсэн байдалд хяналт тавина.

5.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаа, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлтийг ил тод байлгана.

5.4. Төв, орон нутгаас ирүүлсэн тандалтын тайлан, мэдээллийг нэгтгэн санал боловсруулж шийдвэр гаргагчид мэдээлнэ.

Зургаа. Шийдвэр гаргагчийн гүйцэтгэх үүрэг

6.1. Тус журмын 2.15-д заасан үүргийг гүйцэтгэнэ.

6.2. Халдварт өвчний дэгдэлт бүртгэгдсэн тохиолдолд тандалтын багийг томилох, тухайн өвчин бүртгэгдсэн үед мөрдөх заавар, журмын дагуу хариу арга хэмжээг хэрэгжүүлэх бодит нөөц, боломж, санхүүгийн эх үүсвэр байгаа эсэхийг тодорхойлно.

6.3. Тандалтын үр дүн болон шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавина.

Долоо. Хүлээх хариуцлага болон бусад зүйлийн талаар

7.1. Шалтгаангүйгээр тандалтын ажлыг гүйцэтгээгүй болон мэдээ мэдээллийг огт бэлтгээгүй, буруу арга зүйгээр гүйцэтгэсэн, хугацаа хожимдуулснаас учран гарах сөрөг үр дагаварыг тухайн хариуцагч этгээдэд хүлээлгэж захиргааны хариуцлага тооцно.

7.2. Мэдээний үнэн бодит байдлыг мэдээг бэлтгэсэн болон боловсруулсан тал бүрэн хариуцна.

7.3. Энэхүү журам нь хэлэлцэгдэж батлагдсанаар хүчин төгөлдөр болно.

7.4. Журмын хэрэгжилтэнд төрийн захиргааны шат шатны мал эмнэлгийн байгууллага хяналт тавина. Шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны зөвлөлийн хурлаар нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох саналыг хэлэлцэнэ.